



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/16

Шивээговь сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацааг сунгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Иргэн Мухар овогтой Дамбын Хишигтогтох /ТИ68042185/ нь Шивээговь сумын 2 дугаар баг, Хаялга усны урд талд байрлах Төмс, хүнсний ногоо тариалах зориулалттай 40000 м2 газрын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах хүсэлт гаргасан тул 40 жилийн хугацаатайгаар сунган эзэмшүүлсүгэй.

2.Хуулийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулан авч буй иргэн Д.Хишигтогтоход газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг хуулийн дагуу сунгаж буй иргэн Д.Хишигтогтохтой газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2008 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 125 дугаар захирамжийн хавсралтын 7 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Н.СУГАРМАА